



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

201 2 оны 10 сарын 26 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2011 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай

Монгол улсын Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 7 дугаар заалт, Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, Үндэсний статистикийн хорооны саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2011 оны орлогод тооцох жилийн хүүгийн хэмжээг 25.4 хувиар баталсугай.

Хоёр. Энэхүү тогтоолоор баталсан хүүгийн хэмжээг баримтлан даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2011 оны орлогод хүү тооцох арга хэмжээг 2012 оны 4 дүгээр улиралд багтаан авч хэрэгжүүлэхийг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Ц.Уртнасан)-т үүрэг болгосугай.

Гурав. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавихыг Ажлын албанд даалгасугай.

ДАРГА



С.ЭРДЭНЭ